Улаанбаатар хотын АДХ Гүйцэтгэх Захиргааны гишүүдийн хуралдааны 1961 оны 1-р сарын 26-ны өдрийн 7 дугаар т о г т о о л о о р батлав.

## Улаанбаатар хотын 1-р номын сангийн зөвлөлийн дүрэм.

Номын сангийн зөвлөл нь номын сангийн үйлчилгээ, олон нийтийн ажил, ялангуяа ном хэвлэлийн уншлага, ухуулага сурталчилгааны ажлыг хөдөлмөрчин олон түмний дотор төрөл бүрийн хэлбэрээр зохион явуулахад нь туслах, номын санг олон түмэн уншигчаар хүрээлүүлэх зорилгоор номын сангийн дэргэд байгуулагдана

### Нэг. Зохион байгуулалт.

1. Номын сангийн зөвлөл нь уг номын сангийн орчин тойрны үйлчилж байгаа уншигчдын дотроос ном хэвлэлийг уншиж ажиллах талаар үлгэр жишээч бөгөөд номын сангийн үйл ажилд туслагч идэвхтэн уншигчдын тэргүүний хэсгээс бүрэлдэн, байгуулагдана.
2. Номын сангийн зөвлөлийн бүрэлдүүн нь Улаанбаатар хотын АДХГ За-хиргааны гишүүдийн хуралдаанаар батлагдана.
3. Номын сангийн зөвлөл нь номын сангийн зөвлөлийн дарга, гишүүд 7-9 хүний бүрэлдүүнтэй байгуулагдана.
4. Номын сангийн зөвлөлийн даргыг мөн хүү номын сангийн зөвлөлийн гишүүдийн хурлаар сонгон батлана.
5. Номын сангийн зөвлөлийн дарга нь номын сангийн зөвлөлийн ажил хэргийг ерөнхийд нь эрхлэн удирдана. Мөн хүү зөвлөлийн гишүүд нь тус бүрдээ номын сангийн ажлын аль нэгэн хэсгийг хариуцсан тодорхой ажлын хуваартай байна.

Ажлынхаа хуваарыг гишүүдийнхээ хурлаар хэлэлцэж батлана.

6. Номын сангийн зөвлөлийн гишүүдийн хурлыг улирал дутам 1-2 удаа хийж хурлаар зөвлөлийн хийх ажлын төлөвлөгөө, түүний биелэлт гүйцэтгэл, уншигчдаас тавьсан санал хүсэлт, энэ талаар авах арга хэмжээний тухай, номын сан, зөвлөлийн ажиллагааны байдал, номын сангийн ажилд зөвлөлийн зүгээс хэрхэн туслах арга хэмжээ ний тухай зэрэг асуудлуудыг хэлэлцэнэ.

7. Номын сангийн зөвлөл нь ажлынхаа төлөвлөгөөг номын сангийн ажлын төлөвлөгөөнөөс үндэслэн түүнд туслахад чиглүүлэн улирлаар төлөвлөж байна.

8. Номын сангийн зөвлөл нь өөрийн хийж явуулсан ажлынхаа тайланг номын сангийн уншигчдын хуралд жилд нэг удаа тавин хэлэлцүүлж байна.

Хоёр. Номын сангийн зөвлөлийн үүрэг

1. Номын сангийн фондыг зохион байгуулах, түүнийг уншигч олон түмэнд өргөнөөр уншуулан ашиглуулах, номын сангийн нийт уншигчид ба идэвхтэн уншигчдын тоог нэмэгдүүлэх мөн бүрэлдүүнийг сайжруулах, хөдөлмөрчдийн ном хэвлэл унших хүсэл эрмэлзэлийг судалж өрнүүлэх, түүний үзэл суртал эрдэм боловсролын хэмжээг дээшлүүлэхэд нь туслахын тулд номын сангийн ухуулага олон нийтийн ажлыг төрөл бүрийн арга хэлбэрүүдээр /нүүдлийн ба чанга уншилага, номын үзэсгэлэн, плакат, ухуулах хуудас, утга зохиолын үдэшлэг, уншигчдын бага хурал , зөвлөлгөөн, уулзалт, ном хэвлэлийн тойм яриа, гэх мэт/ зохион явуулах ажлуудад номын сангийн зөвлөлийн гишүүд нь идэвхтэйгээр оролцон туслах үүрэгтэй байх болно.

2. Номын сангийн зөвлөлийн гишүүд хүн бол ном хэвлэлийг уншин, түүнтэй ямагт нөхөрлөн эрдэм мэдлэгээ дээшлүүлэх, номын санд уншлага хийх талаар бусад уншигч олон түмэнд үлгэр жишээгээ үзүүлэгч бөгөөд өөрийн ба бусад тэргүүний уншигчдын ном уншлагын шилдэг арга туршлагуудыг нийт хөдөлмөрчдийн дунд сурталчилан ухуулах үүрэгтэй байна.

3. Номын сангийн зөвлөл нь номын сангийн уншлага, олон нийтийн ажилд уншигчдыг татан оролцуулах, ялангуяа залуучууд, идэвхтэн уншигчдыг оролцуулан, номын сангийн ажилд туслалцуулах ажлыг зохион явуулана.

4. Номын сангийн зөвлөлийн гишүүд нь номын сангаас зохион явуулах ажлууд болон номын сангийн ажлыг сайжруулан бэхжүүлэх асуудлыг авч хэлэлцэх хэрэгт ажил хэргийн чанартай оролцон, зохих санал зөвлөлгөөнийг өгч байх үүрэгтэй байна.

1961 он 1-р сарын 26.